

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.Улсын Их Хурлаас Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай анхны хуулийг 2003 онд баталснаас хойш нийт 9 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, 2015 онд шинэчилсэн найруулгын төслийг баталсан юм. Уг хууль нь 8 бүлэг, 28 зүйлтэй бөгөөд Монгол Улсад хуулийн этгээд шинээр үүсэн байгуулагдсан, өөрчлөн байгуулагдсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бичгээр болон цахим хэлбэрээр бүртгэх, иргэн, хуулийн этгээдэд лавлагаа олгох, улсын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна¹.

Хэдийгээр энэ хууль хэрэгжээд удаагүй байгаа боловч зарим зохицуулалтыг дахин нягтлах, алдаа дутагдлыг засаж сайжруулах, хуулийн хэрэгжилт, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагын үүднээс, түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Засаглалын бодлого хэмээх Тавдугаар бүлгийн 5.2.8-д “Улсын бүртгэлийн ажиллагааг онлайн горимд шилжүүлж, үндэсний цахим баримт бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.” гэж, 5.2.11-д “Хууль, эрх зүйн актуудын давхардал, зөрчилтэй заалтуудыг илрүүлэх, арилгах” гэж, Монгол Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловронгуй болгох үндсэн чиглэл”-д Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг шинэчлэн найруулах гэж тус тус заасны дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн зохицуулалтыг Иргэний хуулийн агуулга, үзэл баримтлалд нийцүүлж улсын бүртгэлийн байгууллагаас бүртгэх хуулийн этгээдийн төрлийг шинэчлэн тогтоож, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуультай уялдуулан зарим нэмэлт, өөрчлөлтийг тусгах замаар хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах шаардлагатай байна.

Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т “Хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно.”, 33 дугаар зүйлийн 33.1-д “Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр байгуулна.”, 33.2-т “Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна.” гэж хуулийн этгээдийн төрлийг, мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу

¹Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 8 дугаарт нийтлэгдсэн

татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно.” гэж хуульчилсан байдаг².

Гэтэл Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд холбоо, санг бүртгэх эсэх талаар хэрхэн зохицуулж байгаа нь тодорхойгүй, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээ, эрүүл мэнд, боловсрол зэрэг хуулийн этгээдийн шинэ хэлбэрийг үүсгэж улсын бүртгэлд бүртгэхээр тусгажээ. Эдгээр нь Иргэний хуулиар тогтоосон ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээдийн аль хэлбэрт хамаарах нь ойлгомжгүй байна.

3.Эрх зүйн зохицуулалтгүй байдлаас шалтгаалж иргэдэд ойлгомжгүй, хэрхэн шийдвэрлэх нь маргаантай нөхцөл байдал үүсэх тохиолдлууд олон байна. Тухайлбал; хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллага нь иргэн, хуулийн этгээдэд гэрчилгээ болон тамга, тэмдэг, баталгааны хяналтын дугаарыг олгодог. Гэтэл хуулиар гэрчилгээ болон тамга, тэмдгийн хяналтын дугаарыг шинээр олгох, өмнөх тамга, тэмдгийг хүчингүйд тооцох талаар зохицуулалт байхгүйгээс хувьцаа эзэмшигчид буюу үүсгэн байгуулагчдын хооронд шийдвэрлэхэд хүндрэлтэй маргаан үүссээр байна.

Мөн хуулийн этгээдийн нэр баталгаажуулах зохицуулалтыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар зохицуулж байгаа хэдий ч хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газарт нэр олгох, хуулийн этгээд татан буугдсан, оноосон нэрээ өөрчилсөнийг улсын бүртгэлд бүртгүүлэх хугацааны талаарх зохицуулалт байхгүй байна.

Бүртгэлийн байгууллагаас гаргасан тоон мэдээллээр 2016 оны жилийн эцсийн байдлаар 1968 салбар, төлөөлөгчийн газар бүртгэлтэй байгаагаас шинээр 207 салбар бүртгэгдэж, хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар бүртгэгдээгүй гэсэн судалгаа байгаа бөгөөд нэр олгох талаар зохицуулалт байхгүйгээс ойлгомжгүй байдал үүсдэг³.

4.Хууль хэрэгжиж эхэлснээс хойш практикт үүсээд буй бэрхшээлүүд, тухайлбал, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т хуулийн этгээд нь өөрийн хувийн хэргийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг ажлын 15 хоногийн дотор улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэхээр заасан бөгөөд эрх бүхий төрийн байгууллагаас зөвшөөрөл авдаг өөрчлөлтийн хувьд хуулийн этгээд нь энэ хугацаанд өөрчлөлтөө бүртгүүлж амжихгүй байх тохиолдлууд олон байдаг.

5.Хуулиас дээгүүр болзол шаардлагыг дүрэм, журмаар тогтоохоос татгалзаж, дүрэм журмаар зохицуулж байгаа зарим суурь харилцааг хуулийн хүрээнд илүү тодорхой, нийтэд ойлгомжтой байдлаар зохицуулна.

6.Хуулийн төсөлд соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэнд, хэвлэл мэдээллийн байгууллагыг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн төрлөөс хасаж төслийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т заасан компани, эсхүл 8.1.3-т заасан холбоо /төрийн бус байгууллага/-ны хэлбэрт ангилан бүртгэх, төрийн байгууллага, албан газар болон улсын төсөвт үйлдвэрийн газрыг ангилан бүртгэхтэй

² Иргэний хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн

³ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тоон мэдээлэл, 2017 он

холбогдуулан улсын бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах, шинэчлэх, хувийн хэргийн бүрдүүлэлтийг хангахтай холбогдсон арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор энэ хуулийн төслийг дагалдуулан дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл дараахь бүтэцтэй байна. Үүнд:

Хуулийн төслийн 1 дүгээр бүлэг:“**Нийтлэг зохицуулалт**”-д нэр томъёоны тодорхойлолт, хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар үүсэх үндэслэл, улсын бүртгэлийн үйлчилгээ авах хэлбэрийн талаар тусгах бөгөөд “хуулийн этгээдийн нэр” гэснийг Иргэний хуульд нийцүүлж тодорхойлон, мөн зарим нэр томъёог жигдэлнэ.

Хуулийн төслийн 2 дугаар бүлэг:“**Улсын бүртгэлийн байгууллага, түүний чиг үүрэг**”-т тус байгууллагаас улсын бүртгэлд бүртгэх хуулийн этгээдийн төрлийг шинэчлэн, хэвлэл мэдээлэл, соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн байгууллага гэснийг хасаж Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасан “Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэр...”, мөн зүйлийн 33.2-т “Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэр...”-т тус тус хамааруулж бүртгэж байхаар зохицуулна.

Мөн улсын бүртгэлийн байгууллагын чиг үүргийг тодруулж, эрх зүйн зохицуулалтгүй байдлаас үүсдэг зарим маргаантай асуудлыг зохицуулна. Тухайлбал, улсын бүртгэлийн гэрчилгээ болон тамга, тэмдгийн хяналтын дугаар дахин олгох үндэслэл, журмыг тогтооно.

Хуулийн төслийн 3 дугаар бүлэг:“**Хуулийн этгээдийн хувийн хэрэг**”-т хуулийн этгээдийн хувийн хэрэг бүрдүүлэх зарчим, хэлбэр, хуулийн этгээдийн хувийн хэргийн агуулга, хувийн хэргээс лавлагаа олгох журам зэргийг тогтоож, улсын бүртгэлийн зарим суурь харилцааг хуулийн хүрээнд зохицуулна.

Хуулийн төслийн 4 дүгээр бүлэг:“**Шинээр байгуулсан хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх**”-д хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх хугацаа, хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах, шинээр байгуулсан хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл гаргах, өргөдөл гаргах эрх бүхий этгээд, улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардах баримт бичиг, шинээр байгуулсан хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхээс татгалзах зэрэг харилцааг зохицуулна.

Хуулийн төслийн 5 дугаар бүлэг:“**Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх**”-д хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдөл гаргах, улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардах баримт бичиг, хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх журмыг тусгана.

Хуулийн төслийн 6 дугаар бүлэг:“**Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх**”-д мэдээлэлд оруулсан өөрчлөлт болон эрх шилжүүлэх өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд

шаардах баримт бичгийн жагсаалтыг зарчмын хувьд хэвээр үлдээж зарим шаардлагуудыг шинээр нэмж тусгана.

Хуулийн төслийн 7 дугаар бүлэг: **“Хуулийн этгээдийн татан буулгасныг улсын бүртгэлд бүртгэх”**-д хуулийн этгээдийг татан буулгасан тухай улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэх, татан буулгасныг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхэд шаардах баримт бичиг, татан буулгасныг бүртгэх журмыг тусгана.

Хуулийн төслийн 8 дугаар бүлэг: **“Бусад зүйл”**-д хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаарх зохицуулалтыг илүү төрөлжсөн хуулийн хүрээнд буюу Улсын Их Хурлаас баталсан Зөрчлийн тухай хуулийн хүрээнд зохицуулахаар тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, эрх зүйн дараахь үр дагавар гарна:

1.Хууль хэрэгжих хугацаанд практикт үүсээд буй тодорхой асуудлуудыг шийдвэрлэж, хуулийн этгээдийн улсын бүртгэл хийхэд эрх зүйн зохицуулалтгүй байдлаас үүдэн иргэд, бүртгэлийн байгууллагад үүсдэг бэрхшээлүүдийг арилна.

2.Бүртгэлийн суурь харилцааг хуулийн хүрээнд илүү тодорхой, ойлгомжтой байдлаар зохицуулж хуулиас дээгүүр болзол шаардлагыг дүрэм, журмаар тогтоохоос татгалзаж хуульд нийцсэн байх зарчим үйлчилнэ.

3.Хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчил арилна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулна.

---o0o---